

МОНГОЛЫН ЦЭРЭГ ПОЛЬШИД ДОВТОЛСОН НЬ

Н.Баярбаатар

Дундад зууны үеийн монголын түүхийн бичлэгт XII-XIII зуунд Монголын хаадын байлдан дагууллыг өгүүлсэн эх сурвалж, шастир, тэмдэглэл болон бусад магад үнэн баримт материал зонхилох хэсгийг агуулдаг. Тухайн үед Монгол Улсад арга буюу дарлагдсан Азийн улс түмний гадна Европ тивийн орнуудад монголчуудын цэргийн урлаг, тэдний эзэрхэг түрэмгий үйл ажиллгааны тухай мэдээ сэлт дээд лам, хаад язгууртнаар дамжин ард түмний дунд өргөн дэлгэрэх болж санаа сэтгэлийг нь ихэд түгшээх болжээ. "БНМАУ-ын түүх" нэгэн боть зохиолын гуравдах хэвлэлд XIII зуунд энэ тивд явуулсан Монголын довтолгооныг өгүүлсэн байдаг. Эл өгүүлэлд тухайн үед Польшид болж өнгөрсөн үйл явдлыг товчхон танилцуулахыг оролдов.

Европын улс түмнээс монгол цэрэгтэй анх нүүр учирч аюул заналд автсан нь орос, польш, унгарчууд байлаа.

1241 оны хаврын эхэн сард монголын цэрэг Унгар, Польшийн чиглэлээр Киевээс баруун зүг мордов. /Зарим түүхчид Бат хаан польш нутгаар дайран өнгөрч Унгар хүрэх бодолтой байсан гэж үздэг. Гэвч Сан голын эрэг дээрх Пшемысль гэдэг хотоос монголын цэрэг хоёр хэсэгт хуваагджээ. /Н.Б./

1138 онд Болеслав Кжывоуст хааны гэрээслэл дагуу түүний хөвгүүд нэгдмэл улсаа хуваан авч захирчээ. Үүнээс хойш хан хөвгүүдийн үр удам нь өөр хоорондоо байнга тэмцэлдсээр өгүүлэн буй үед нэгдмэл улс дотор тархай бутархай байдал зонхилоод зуу гаруй жил нэгэнт болсон байлаа. Хэдийгээр ийм байдал тогтсон авч нийт газар нутгийнхаа ирээдүйн хувь заяанд өөрийн гүйцэтгэх үүргийг хөвгүүд ойлгож нийслэл Краковын хааныг ёс төдий ч бол өргөмжилсөөр иржээ. Иймэрхүү улс төрийн дотоод байдал Орос, Чех болон европын бусад орнуудад нэлээд түгээмэл байсан нь нэгдмэл улс байгуулагдахын бодит процесс байсан ба тархай бутархай байдлын сул талуудыг дэлхийн бүх улс, үндэстний түүх сургамжлан ирсэн билээ. Нэг үндэстний салангид байдлын уршигт шинж тэмдэгүүд нийгмийн хөгжлийн янз бүрийн шатанд янз бүрийн хэлбэрээр уламжлагдан үлдэж өнөө үед ч илэрсээр байна.

1241 оны 3-р сарын 18-ны өдөр Краков, Сандомерынцэрэг Хмальник хэмээх тосгоны дэргэд Сүбэдэй, Байдар нарын удирдсан цэрэгтэй хүч тулсныг түүхч Ян Двугош өгүүлсэн нь ... "Татарууд хүчээ сэлбэж байхаар хоёр хэсэг болон хуваагдаж нэг нь польшууд уруу довтлов. Польшууд хүчээ нэгтгэн бөөгнөрүүлсэн тул туслах хүч үгүй. Татарын энэ хэсэгтэй польшууд... хэдэн цагийн турш баатарлаг тулалдаж... тэдгээрийн эрэмгий зоригт дайчид дарга нарыг дийлэв... Польш дарга нар цэрэг лугаа нэгэн адил үүргээ гүйцэтгэн хэд хэдэн удаа тэмцлээ үргэлжлүүлэв. Гэвч тэд ч эрэхлэг баатарлагаараа амиа алдав"...

*Монгол Экспедишнс ХХК
Ерөнхий менежер

Энэ тулалдаанаас амь үлдэгсэд 19-ний өдөр Тарчек тосгоны дэргэд эгэн зэвсгээ зөрүүлсэн авч мөн амжилтгүй болсноор нийслэл Краков орох зам монголчуудад нээгджээ. Харийн эзэрхий нарын явах чиг дагуу байрласан хот, тосгодын ард иргэд орон гэрээ орхин зугтаан ойд орогнож байлаа. Монголчууд Краков хүрээд зогссонгүй нутгийн гүнд нэвтэрч 4-р сарын 1-ний өдөр Шлёнск косводын төв Броцлавд тулж очив.

Шлёнскийн хаад ноёдын амралтын газар байрласан жижиг хот Легница байгаль орчин, уран барилгаараа алдартай. Хотын ойролцоох өргөн тал газрыг дундад зууны үед Сайн тал гэж нэрлэдэг байв. Чухам энд 1241 оны 4-р сарын 9-ний өдөр Хенрик Побожны хаан краков, шлёник, их польшийн восводын хүчийг моравчуудын цэрэгтэй нэгтгэн харийн түрэмгийлэгчтэй цус урсгасан ширүүн тулалдаан хийж арга буюу дийлджээ. Энэ тулалдааны явцыг дөрвөн хэсэгт хувааж болох бөгөөд монголчууд байлдааны тактикаа эсрэг этгээдийн эгнээнд урьд өмнө Оросоос олзолсон цэргүүдийг илгээж самуун дэгдээлгэх /олзлогдсон оросууд польшийн цэрэгт элсэн орж тулалдааны шийдвэрлэх үед тал тал тийш зугтаж моравчуудын цэрэг дийлдсэнээр хааны зүүн жигүүр суларчээ. /Н.Б./ хийн зэвсэг ашиглах зэрэг европ цэргийн хэрэгт урьд өмнө үзэгдээгүй зүйлүүдийг ашигласнаар тулалдааны хувь заяаг шийджээ. Мөн Чехийн хаан Вацлав I цэргийн туслалцаа үзүүлж амжаагүй ажээ.

Легницгийн тулалдаанд монголын цэргийн хүч үлэмж хэмжээгээр суларч европ тивийн гүнд нэвтрэх зорилго нь балран унан нөгөө талаар монгол улсын дотоод байдлаас шалтгаалан, тухайлбал шинэ хаан сонгох чухал хуралдайд оролцохоор Бат хаан Австри орны хавиас нутгийн зүг эргэн буцсанаар түүний европд хийсэн довтолгоон төгссөн аж. Ийнхүү XIII зуунд монгол цэрэг таван зуун жилийн турш Польш оронд үе үе довтолсноос 1241, 1259, 1287 онуудад эндэхийн ард түмэнд нүсэр их гай гамшиг учруулсан гэж польшийн түүх бичлэгт үздэг. Нөгөө талаар гаднын түрэмгийлэл олон жижиг хаант улсыг нэгтгэж 1259 онд Польшийн хаант улс байгуулагдах процесст нөлөөлсөн гэж үзэх болох юм.

Врацлаваас Легниц хот хүрэх өргөн дардан зам Легницийн талаар дайрч өнгөрнө. Жуулчид, өргөн олныг үзэж сонирхохыг урьсан тэмдэгийн заасан чигээр явбал дундад зууны барок маягаар босгосон сүмд хүрч очно. Энэ сүмийг 1741 онд буюу харийн түрэмгийлэгчдийн эсрэг баатарлагаар тэмцэж амь үрэгдсэн польшийн ард түмний дурсгалыг мөнхжүүлж, европын түүхийн дундад зууны үеийн хамгийн баатарлаг тулалдаан хэмээн түүхэнд нэрлэгддэг энэ үйл явдлын 500 жилийн ойд зориулан барьж байгуулсан ажээ.

НОМ ЗҮЙ

1. JUDWIK Bazyłow, Historia Mongolii, Wrocław 1981
2. Miroslaw Przytecki, Legnickie Poll, Wrocław 1973
3. Stefan Kwakowski, Polska w Walce z Najazdami Tatarskimi, Wawrsada, 1956
4. Vasiienica, Polska Piastow, Wawrsawa, 1979
5. М.И.Гольман, Изучение истории Монголии на западе XIII - середина Ххв., Москва 1988